# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 08 дугаар сарын 21 Дугаар ЗТ-057/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажилд Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамж шийдвэрээр байгуулагдсан 5 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комисс 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн тохижилтын ажил түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: Байхгүй.

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр, дугаар: ХТСИ_03/25

2.3. Захиалагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011122089, регистрийн дугаар: 2659603, хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Наадамчдын зам 1200, Арцатын ам, холбоо барих утас: 11-325044, цахим хаяг: www.ulaanbaatar.mn,

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9014001122, регистрийн дугаар: 6108938, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ19-590/17; хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Залуучуудын гудамж өөрийн байр, холбоо барих утас: 11-453501, цахим шуудангийн хаяг: htg@ub.gov.mn

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Дабльпирамид Констракшн ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011461026, регистрийн дугаар: 5797683, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ18-172/22; хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Хүннү-2222, Их Монгол улсын гудамж, А-98 тоот, холбоо барих утас: 88113524,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000159009, регистрийн дугаар: 5369568, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар: ЗТ19-449/23, хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын ам, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор Б барилга, 9 давхар, холбоо барих утас: 11-320769, цахим шуудангийн хаяг: info@upri.ub.gov.mn

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000026125, регистерийн дугаар: 9088741, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, холбоо барих утас: 11-360354,

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийн их зас
шинэчлэлтийн ажлыг ашиглалт
оруулах комисс

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

☐ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, ОН2512001853001 тоот гэрээний дугаартай Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажилд түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү тохижилтын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;
б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 3 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 12 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай,
Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв
Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажил

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичиг:
Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Ц.Очироо)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

---о0о---

МЭДЭЭЛЛИЙН САН БҮРТГЭЛ
Объект ...
Огноо: 2025 он ... сар ... өдөр
Бүртгэсэн:
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИНТНЫ ТӨВ ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН ТӨВ ТАЛБАЙН ТОХИЖИЛТЫН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР

2025 оны 07 дугаар сарын 08 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, НО2512001853001 тоот гэрээний дугаартай, Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын хурал 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11:00 цагт, тус газарт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдав.

Комиссын бүрэлдэхүүн:

1. Комиссын дарга:
   Хяналт шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — А.Мөнгөн
2. Комиссын нарийн бичгийн дарга:
   Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хэлтсийн дарга — Г.Эрдэнэбаатар

Комиссын гишүүд:

3. Ашиглагч байгууллага:
   Монголын Бурханы шашинтны Төв Гандантэгчэнлин хийдийн Тамгын лам — Э.Баяр
   Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга — Г.Мөнх-эрдэнэ
4. Зураг төсөл зохиогч байгууллага:
   Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын архитектор — Б.Их-Аз
5. Нийслэлийн Архивын газар Улсын байцаагч — О.Жүгдэрнамжил

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 6
- Хүрэлцэн ирсэн – 6
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 6

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд засварын ажлын гүйцэтгэлийг хянан, баримт бичигтэй танилцаад дараах саналуудыг гаргав.

Гүйцэтгэгч байгууллага: Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хэлтсийн дарга **Г.Эрдэнэбаатар**

- Комиссын нийт гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах санал гаргав.

Зураг төсөл зохиогч байгууллага: Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын архитектор **Б.Их-Аз**

- Жанрайсиг мөргөлийн дуганы хойд талын одоо байгаа хашаа явган зам хооронд үлдсэн хэсгийг хайргаар дүүргэх.

Ашиглагч байгууллага: Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тамгын лам **Э.Баяр**

- Хойд хашааны дагуух зайг бөглөх.
- Зүүн хойд талд тэргэнцэртэй хүний налуу гаргах.
- 2ш хогийн савны суурьны чулууг гүйцээж хийх.
- Голын хүйсэн дээрх цагаан чулууг засах.
- Чанга яригч ажилд оруулах.
- Худгийн таг засварлаж сайжруулах.
- Өндөр гэгээний хөшөөний урд гарц гаргах /шилжүүлсэн ажлын тоо хэмжээнд оруулах/

Ашиглагч байгууллага: Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга **Г.Мөнх-Эрдэнэ**

- Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагад хүлээлцэх /Төгс гэрэлтүүлэг ХХК/
- Борооны усны хаялгын түвшин тааруулах.
- Налуу буюу пандус хэсэгт бариул хашлага төлөвлөх.
- Төв цэгийн цагаан өнгийн хавтан солих.
- Нүдэн гэрэл кабель хуягтай хийсэн эсэх фото зургаар ирүүлэх.
- Зарим байршилд тэгш байдал алдагдсан хэсгүүдийг засварлах, чигжээс сайн хийх.

Нийслэлийн Архивын газрын Улсын байцаагч **О.Жүгдэрнамжил**

- Зураг төсөв боловсруулах гэрээ эх хувь бүрдүүлэх.
- Магадлалын дүгнэлт эх хувь бүрдүүлэх, хавсралтын хамт.
- Замын хавтанг буулгаж, тээвэрлэж ашиглагч байгууллагатай хүлээлцсэн акт эх хувь бүрдүүлэх.
- Ил далд ажлын актыг дугаарлаж тэмдгээр баталгаажуулах.
- Ажлын явцын фото зургийг стандартын дагуу үйлдэж, тайлбарыг тодорхой дахин хийлгэж бүрдүүлэн он, сар, өдөр үйлдэх.
- Жагсаалтын дагуу баримтын бүрдлийг хангаж төрийн архивт актаар хүлээлцэх.
- Нэмэлт фото зургийг тайлбарын хамт оруулах.
- Баримтын хуудас дугаарлах.
- Чанарын баталгаа бүрдүүлэх.
- Ашиглагч байгууллагатай хүлээлцсэн акт бүрдүүлэх.
- Дотоод товьёог баталгааны хуудас үйлдэх.
- Төсөв, эх хувь бүрдүүлж, төсвийн гүйцэтгэл.
- Бэхлэгчийн горим шинжилгээ бүрдүүлэх

- Бараа материалын орчуулга бүрдүүлэх
- Хуягтын кабелийн тайлбар

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- Ил далд ажлын акт фото баяжилт хийх.
- Худгийн таг засах 8 ширхэг.
- Хогийн савны тамхи унтраагуур таглах /цэвэр үзэмжтэй, өнгө дагуу/
- Цамхагт гэрлийн салхины ачааллын тооцоо, тодорхойлолт.
- Бетон маркын сорьц, шинжилгээний бичиг /гэрлийн суурь, замын бэлтгэл/
- Ажлын тоо хэмжээг тулган захиалагчийн хяналт, ашиглагчид актаар хүлээлцэх.
- Бараа материалын сертификат гэрчилгээ орчуулга.
- Тоноглолыг бүрэн ажиллагаанд оруулж, тохируулга хийх, акт үйлдэх /холбоо/
- Чанарын баталгаа гаргах.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгатай, НО2512001853001 тоот гэрээний дугаартай, Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн төв талбайн тохижилтын ажлыг комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан.
Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн.
Комиссын нарийн бичгийн дарга:
Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын
Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга (Ц.Очироо)